



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 1/156

Баян-Өндөр сум

Г Засаг даргын Тамгын газрын бүтэц,  
орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2, 67.4, 67.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6, 37.1.13, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай”, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”, аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн A/701 дүгээр захирамж, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10.3.6 заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ангилал, зэрэглэл, гүйцэтгэх чиг үүрэг, орон тоог өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын албан хаагчдын бүтэц орон тоог хавсралтад зааснаар баталж алба, нэгжид хуваан баталсугай.

2. Бүтэц, орон тоог өөрчлөн баталсантай холбогдуулан гарах зардлыг цалингийн санд багтаан тооцож албан хаагчдад олгохыг Нягтлан бодогч (А.Адъяадолжин)-д үүрэг болгосугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан “Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын бүтэц, орон тоог батлах тухай” Тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ний A/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (Б.Энхжаргал)-д даалгасугай

ДАРГА   
Ш.ӨЛЗИЙБАЯР

6124030435

Баян-Өндөр сумын Засаг даргын  
Тамгын газрын даргын 2024 оны  
12.. дугаар сарын 27.-ны өдрийн  
12.. дугаар тушаалын хавсралт

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО**

Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Албан тушаалын тоо
<b>Сумын Засаг дарга</b>	<b>ТУТ</b>	<b>1</b>
Засаг даргын Орлогч	ТУТ	1
Тамгын газрын дарга	T3-5	1
<b>1. Төрийн захиргаа удирдлагын алба 10</b>		
Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (Албаны дарга)	T3-9	1
Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Хяналт шинжилгээ, үнэлгээ, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Тогтоол шийдвэрийн биелэлт, төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Иргэд, олон нийт, гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Төрийн байгууллагын зохион байгуулалт хариуцсан ажилтан	TY-6	1
Засаг даргын зөвлөх	TY-5	1
Архив-бичиг хэргийн эрхлэгч	TYM-3	1
Нарийн бичиг	TY-4	1
Оператор	TY-2	1
<b>2. Санхүү төрийн сангийн алба /Үйлчилгээний нэгжтэй / 20</b>		
Санхүүгийн албаны дарга	T3-7	1
Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	T3-8	1
Хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Худалдан авах ажиллагаа, өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Ахлах нягтлан бодогч	TYM-7	1
Нягтлан бодогч	TYM-6	1
Нярав	TY-4	1
Аж ахуй хариуцсан нарав	TY-4	1
Слесарь	TY-3	1
Жолооч	TY-3	3
Жижүүр	TY-1	4
ЗДТГ-ын үйлчлэгч	TY-1	3
Спорт заалны үйлчлэгч	TY-1	1
<b>3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн алба 12</b>		
Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Албаны дарга)	T3-7	1
Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний хяналтын улсын байцаагч	T3-7	1
Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Хот төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1

Хот тохижилт, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Бэлчээр, тэжээл, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Байгаль хамгаалагч	TY-4	1
Газрын асуудал хариуцсан ажилтан	TY-4	2
СӨХ, орон сууцны хорооллын тохижилт хариуцсан ажилтан	TY-4	1

#### **4. Нийгмийн бодлогын алба 8**

Зохион байгуулалт, баг хариуцсан мэргэжилтэн (Албаны дарга)	T3-9	1
Статистикч	T3-9	1
Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Боловсрол, соёл, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
Биеийн тамирын арга зүйч	TY-6	1
Статистикч	TY-5	1
Сургалт, хөгжлийн ажилтан	TY-4	1

#### **5. Хэвлэл мэдээллийн алба 5**

Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч (Албаны дарга)	TY-7	1
Мэдээлэл технологийн ажилтан	TY-7	1
Эх бэлтгэл, дизайнер	TY-6	1
Сэтгүүлч	TY-6	1
Зураглаач	TY-6	1

#### **6. Багуудын ажлын алба**

Багийн Засаг дарга	ТУТ	26
Багийн зохион байгуулагч	T3-10	26
Багийн нийгмийн ажилтан	T3-10	26

--- оОо ---